

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ХАРЬЯА ДАВТАН
СУРГАЛТ, СЭРГЭЭН ЗАСЛЫН
ТӨВИЙН ДАРГА, ХОШУУЧ
Ц.УРАНЧИМЭГ ТАНАА

2019.02.25 № 06/219
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ОБЕГ-ын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

ОБЕГ-ын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ОБЕГ-ын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

ОБЕГ-ын харьяа Давтан сургалт сэргээн заслын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга, хошууч Ц.Уранчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ОБЕГ-ын харьяа Давтан сургалт сэргээн заслын төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ОБЕГ-ын харьяа Давтан сургалт сэргээн заслын төвийн 2018 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа, Э.Энхбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төв 2018 оны санхүүгийн тайлангаа Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дугаар сарын 29-ний өдрийн 13/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төв нь амралт сувилгааны таатай орчинг бий болгож, үйлчлүүлэгчдээ дээдлэн ажилтан бүрийнхээ амжилтаар бахархах манлайлагч хамт олон байх эрхэм зорилготой үндэсний жишиг болохуйц үйлчилгээний байгууллага байх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Давтан сургалт
- Сэргээн заслын үйл ажиллагаа

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Aculous” програм хангамж ашигладаг байна.

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын 2 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь нийт орлогыг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төвийн 2018 оны нийт орлого 19,025.07 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 19,025.07 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд сонгосон хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	11,441.4	
2	Албан шаардлага өгсөн	1	-	
	Дүн	1	11,441.4	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Төсвийн цаглабар

Тус төв нь 2018 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дугаар сарын 29-ний өдөр 12/15 дугаар бүхий албан бичгээр ирүүлж хуулийн хугацаанаас хуанлийн 4 хоногоор хоцроосон нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Хариуцлага тооцох албан шаардлага өгөх

2.8.1.2 Санхүүгийн тайлангийн залруулга

Мөнгөн гүйлгээний тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,668.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, өөрийн хөрөнгөөр 113,990.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан боловч мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардалд тайлагнаагүй, урьдчилж орсон орлого 40,000.0 мянган төгрөгийг тайлант оны орлогоор тайлагнасан, байгууллагад төлөх өр төлбөр 12,026.0 мянган төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн зэрэг алдаа илэрсэн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад 167,685.1 мянган төгрөгийн алдааг залруулсан

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллага нь Засгийн газрын 2015 оны 479 дүгээр тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газраас 4,430,099.5 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч 2016 онд Улсын төсөвт үйлдвэрийн газрын гэрчилгээ авсан байна. Гэвч тус байгууллага нь улсын төсвөөс санхүүжилт авдаггүй өөрийн орлогоор зардлаа санхүүжүүлж үйл ажиллагаа явуулдаг боловч Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу санхүүгийн тайлангаа гаргасан байна.

Мөн ОБЕГ-ын даргын 2018 оны А/67 дугаар тушаалаар тус байгууллагын орон тоог 41 албан хаагчтай байхаар баталснаас 24 албан хаагчдын нийт 147,720.2 мянган төгрөгийн цалинг 5 аймгийн Онцгой байдлын газраас, цалингийн зөрүү 16,883.7 мянган төгрөгийг тус төвөөс олгосон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3-д “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын

төсөвт үйлдвэрийн газар гэнэ” гэж заасны дагуу улсын төсвийн санхүүжилтийн асуудлыг санал тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 951,253.4 мянган төгрөгийн орлоготой, 901,608.6 мянган төгрөгийн зардалтай ажилласан бөгөөд тайлант онд улсын төсвөөс санхүүжилт аваагүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайланд түүврээр аудит хийж ОБЕГ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь ОБЕГ-ын харьяа давтан сургалт сэргээн заслын төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Өмнөх оны санхүүгийн тайланд татвар, НДШ-ийн 7,781.5 мянган төгрөгийг өр төлбөрөөр бүртгээгүй, тайлант онд цалингаас суутгасан ХХОАТ-ын 3,659.9 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Энэ нь үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>330,754,394.16</u>	<u>413,750,928.23</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	39,790,731.66	571,577.58
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,409,664.00	740.00
31110	Төгрөг	00.00	740.00
31130	Нэмэлт санхүүжилт	1,409,664.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	38,381,067.66	570,837.58
3121	Төгрөг	38,381,067.66	570,837.58
31213	Арилжааны банк дахь харилцах	38,381,067.66	570,837.58
33	АВЛАГА	00.00	10,485,994.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	720,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	8,780,000.00
335	Бусад авлага	00.00	985,994.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	985,994.00
35	БАРАА МАТЕРИАЛ	290,963,662.50	402,693,356.65
351	Түүхий эд материал	8,118,826.75	11,702,265.18
35110	Тусгай зориулалттай материал	00.00	00.00
35130	Эм боох материал	8,118,826.75	11,702,265.18
354	Хангамжийн материал	282,844,835.75	390,991,091.47
35410	Бичиг хэргийн материал	3,811,807.60	1,361,287.00
35420	Аж ахуйн материал	204,692,878.72	282,287,817.90
35430	Сэлбэг хэрэгсэл	22,570,330.00	23,292,330.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	800,900.00
35450	Барилгын засварын материал	6,037,740.00	14,457,723.16
35460	Хүнсний материал	5,837,779.43	10,414,128.91
35470	Бусад хангамжийн материал	39,894,300.00	58,376,904.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,649,259,642.06</u>	<u>4,482,698,220.39</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,649,259,642.06	4,482,698,220.39
392	Биет хөрөнгө	3,649,259,642.06	4,482,698,220.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,516,137,920.00	4,209,183,278.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,237,238,654.12	-46,154,918.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	162,107,411.67	42,166,666.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,546,707.96	-28,816,666.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	367,347,304.52	419,051,104.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-306,822,892.02	-324,722,595.57
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	293,360,313.49	338,060,313.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	-259,085,053.52	-269,068,962.06
39216	Дуусаагүй барилга, байгууламж	143,000,000.00	143,000,000.00

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,980,014,036.22</u>	<u>4,896,449,148.62</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>400,854.00</u>	<u>73,336,329.39</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	400,854.00	73,336,329.39
413	Өглөг	400,854.00	33,336,329.39
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	7,454,215.19
4136	Бусад өглөг	400,854.00	25,882,114.20
41361	Байгууллагад төлөх өглөг	400,854.00	20,877,704.20
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	5,004,410.00
414	Урьдчилж орсон орлого	00.00	40,000,000.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	00.00	40,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,979,613,182.22</u>	<u>4,823,112,819.23</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,979,613,182.22	4,823,112,819.23
512	Хуримтлагдсан үр дүн	3,979,613,182.22	3,764,659,883.59
51210	Өмнөх үеийн үр дүн	3,979,613,182.22	3,971,831,676.96
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-207,171,793.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	1,058,452,935.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,980,014,036.22</u>	<u>4,896,449,148.62</u>

Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>590,604,998.13</u>	<u>951,253,460.29</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>127,949,698.09</u>	<u>297,549,835.29</u>
120	Нийтлэг татварын бус орлого	127,949,698.09	297,549,835.29
120002	Хүүгийн орлого	675,142.09	602,899.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	127,274,556.00	288,201,494.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	169,513.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	127,105,043.00	288,201,494.50
120009	Бусад орлого	00.00	8,745,441.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>462,655,300.04</u>	<u>653,703,625.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	462,655,300.04	538,423,625.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,060,000.00	64,127,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	458,595,300.04	474,296,625.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	115,280,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	115,280,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>589,058,037.40</u>	<u>901,684,658.56</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>589,058,037.40</u>	<u>901,684,658.56</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	586,453,037.40	899,634,339.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	70,940,946.00	162,425,514.00
210101	Үндсэн цалин	58,649,898.00	162,425,514.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,291,048.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,462,677.23	16,126,599.96
210201	Тэтгэврийн даатгал	11,462,677.23	10,321,833.00

ОБЕГ-ын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,272,728.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,018,183.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	254,544.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,259,311.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,536,045.50	136,053,502.80
210301	Гэрэл, цахилгаан	40,775,045.50	102,571,806.80
210302	Түлш, халаалт	00.00	33,481,696.00
210303	Цэвэр, бохир ус	761,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,275,221.05	80,632,985.12
210401	Бичиг хэрэг	8,007,770.00	14,325,384.00
210402	Тээвэр, шатахуун	20,382,339.00	6,890,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,870,612.05	6,713,003.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	11,466,810.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	41,121,657.42
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	14,500.00	116,130.00
2105	Нормативт зардал	110,901,307.20	165,969,066.59
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,460,285.56	5,845,938.07
210502	Хоол, хүнс	87,966,779.54	160,123,128.52
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,474,242.10	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,034,531.80	33,805,582.00
210604	Урсгал засвар	28,034,531.80	33,805,582.00
2107	Томилолт, зочны зардал	12,368,500.00	1,808,000.00
210702	Дотоод албан томилолт	12,368,500.00	1,808,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,679,987.00	37,116,859.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,910,887.00	8,113,105.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	186,030.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	552,100.00	319,184.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	28,498,540.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,217,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	254,253,821.62	265,696,230.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,803,355.75	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,049,200.00	13,807,910.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	158,401,265.87	251,888,320.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,605,000.00	2,050,318.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,605,000.00	2,050,318.88
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,605,000.00	2,050,318.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,546,960.73</u>	<u>49,568,801.73</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	515,035,770.49	256,740,595.10
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	515,035,770.49	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	256,740,595.10
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-515,035,770.49	-256,740,595.10
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-513,488,809.76</u>	<u>-207,171,793.37</u>

Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	462,607,955.13	706,439,741.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	844,655.09	4,723,249.79
120	Нийтлэг татварын бус орлого	844,655.09	4,723,249.79
120002	Хүүгийн орлого	675,142.09	602,899.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	169,513.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	169,513.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	461,763,300.04	701,716,492.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	461,763,300.04	586,436,492.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	16,792,867.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,060,000.00	104,127,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	457,703,300.04	465,516,625.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	115,280,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	115,280,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	422,848,312.18	631,668,655.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,848,312.18	631,668,655.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	420,193,312.18	628,876,249.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	73,421,514.00	152,360,156.84
210101	Үндсэн цалин	44,434,883.00	152,360,156.84
210105	Гэрээт ажлын хөлс	28,986,631.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,947,485.63	20,113,874.07
210201	Тэтгэврийн даатгал	18,947,485.63	20,113,874.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,381,022.50	55,977,834.80
210301	Гэрэл, цахилгаан	45,948,522.50	40,155,834.80
210302	Түлш, халаалт	00.00	14,051,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,432,500.00	1,771,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	69,249,232.05	95,669,083.70
210401	Бичиг хэрэг	9,995,235.00	13,200,509.00
210402	Тээвэр, шатахуун	13,083,610.00	18,823,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,910,612.05	6,034,460.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	12,008,810.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	45,602,004.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	39,259,775.00	00.00
2105	Нормативт зардал	90,469,234.00	163,633,641.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,788,695.00	10,604,330.50
210502	Хоол, хүнс	81,687,539.00	149,247,040.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	993,000.00	3,782,270.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,111,914.00	103,823,515.16
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	18,109,000.00
210602	Тавилга	00.00	9,554,800.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	48,000.00	235,000.00
210604	Урсгал засвар	43,063,914.00	75,924,715.16
2107	Томилолт, зочны зардал	12,368,500.00	1,808,000.00
210702	Дотоод албан томилолт	12,368,500.00	1,808,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,496,510.00	16,454,344.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,708,910.00	15,195,030.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	284,040.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	552,100.00	221,174.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	754,100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,235,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,747,900.00	19,035,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,698,700.00	3,030,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,049,200.00	16,005,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,655,000.00	2,792,406.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,655,000.00	2,792,406.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,655,000.00	2,792,406.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	39,759,642.95	74,771,085.92
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	113,990,240.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	113,990,240.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	113,990,240.00
223001	Бусад хөрөнгө	00.00	113,990,240.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-113,990,240.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	39,759,642.95	-39,219,154.08
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,088.71	39,790,731.66
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,790,731.66	571,577.58

Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	4,493,101,991.98	4,493,101,991.98
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-513,488,809.76	-513,488,809.76

C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	3,979,613,182.22	3,979,613,182.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	-7,781,505.26	-7,781,505.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	3,971,831,676.96	3,971,831,676.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	1,058,452,935.64	00.00	1,058,452,935.64
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	-207,171,793.37	-207,171,793.37
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,058,452,935.64	3,764,659,883.59	4,823,112,819.23

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019-02-24	Аудитын нэр:	Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	ОБЕГ-ын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төв			САГ-2019/123/СТА-ТШЗ
				Мянган төгрөгөөр

д д	Аудитын зорилт, чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
1			2	3			4	5
1	Балансын данстай холбоотой	Өмнөх оны санхүүгийн тайланд татвар, НДШ-ийн 7,781.5 мянган төгрөгийг өр төлбөрөөр бүртгээгүй, тайлант онд цалингаас суутгасан ХХОАТ-ын 3,659.9 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.	11,441.4	Зөвлөмж өгөх			Дарга Нягтлан бодогч	Ц.Уранчимэг Х.Цолмон
2	Байгууллагын үйл ажиллагаа	Санхүүгийн тайланг хуулийн хугацаанаас хуанлийн 4 хоногоор хоцроосон нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасантай нийцэхгүй байна.	-	Албан шаардлага			Дарга	Ц.Уранчимэг
		ДҮН	11,441.4					

